



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар A/245

Улаанбаатар хот

- Г Мэдээллийн технологийн нэгжийн албан  
хаагчид мэргэшлийн зэрэг олгох шалгуур  
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлд заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Мэдээллийн технологийн нэгжийн албан хаагчид мэргэшлийн зэрэг олгох нийтлэг болон тусгай шалгуурыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Д.Түвшинтөр/-д даалгасугай.

ДАРГА

Д.МӨРӨН



000000937

Гадаадын иргэн, харьятын газрын даргын  
2019 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн  
A/245 дугаар тушаалын хавсралт

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН НЭГЖИЙН АЛБАН ХААГЧИД  
МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ШАЛГУУР

Дараахь нийтлэг болон тусгай шалгуурыг хангасан мэдээллийн технологийн нэгжийн албан хаагчид мэргэшлийн зэрэг олгоно:

Нэг. Нийтлэг шалгуур

1. Мэдээллийн технологийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй;
2. Бакалаврын зэрэг олгосон их, дээд сургууль нь магадлан итгэмжлэгдсэн;
3. Мэдээллийн технологийн чиглэлээр нэгээс доошгүй жил ажилласан;
4. Орчин үеийн техник, технологийг бие даан судалдаг, өөрийгөө хөгжүүлдэг;
5. Судалгаа хийх, үр дүнг боловсруулах, багаар ажиллах, гадаад хэлний зохих төвшний мэдлэг, чадвартай.

Хоёр. Тусгай шалгуур

1.I зэрэг олгоход:

- 1.1. Мэдээллийн технологийн тусгайлсан сертификаттай сургалтад гурав ба түүнээс дээш удаа хамрагдсан;
- 1.2. Байгууллагад дөрвөөс доошгүй жил ажилласан;
- 1.3. Сүүлийн хоёр жилийн хөдөлмөрийн гэрээний биелэлтийн үнэлгээг А (Маш сайн) болон "Бүрэн хангалттай" үнэлэгдсэн;
- 1.4. Жил тутам нэгээс дээш ажлын хэсэгт орж ажилласан байх.

2.II зэрэг олгоход:

- 2.1. Мэдээллийн технологийн тусгайлсан сертификаттай сургалтад хоёр ба түүнээс дээш удаа хамрагдсан;
- 2.2. Байгууллагад хоёроос доошгүй жил ажилласан;
- 2.3. Сүүлийн хоёр жилийн хөдөлмөрийн гэрээний биелэлтийн үнэлгээг В (Сайн) болон "Хангалттай" үнэлэгдсэн.

3.III зэрэг олгоход:

- 3.1. Мэдээллийн технологийн тусгайлсан сертификаттай сургалтад нэг ба түүнээс дээш удаа хамрагдсан;
- 3.2. Байгууллагад нэгээс доошгүй жил ажилласан.

.....оо.....